



МОНГОЛ УЛСЫН  
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Гадаадад сургах тухай

ТУШААХ НЬ:

1. Сүйдийманангийн Отгонтулгыг АНУ-ын Колорадогийн Их Сургуульд барилгын инженерийн, Ухнайн Бурмаа, Жанчивын Өнөрмаа нарыг Английн Лондон хотын дипломатын академид олон улсын харилцааны мэргэжлээр, Лайлангийн Тунгалагийг Австралийн Куртины Их Сургуульд боловсролын удирдлагын мэргэжлээр, Дорлигсүрэнгийн Үйлстийг АНУ-ын Ютагийн улсын коллежид эдийн засгийн мэргэжлээр, Сэрчиндоржийн Аббийг АНУ-ын Техасын Их Сургуульд эдийн засгийн мэргэжлээр 1999 оноос эхлэн тус тус суралцуулсугай.


2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын Магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай нэг жилийн гэрээ байгуулж, холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Алтангэрэл/-д тус тус даалгасугай.



САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.САЙХАНБИЛЭГ

Танилцсан:



Р.Бат-Эрхэнэ  
С.Алтангэрэл

Хянасан



И.Дордовсүрэн

Зөвлөх, улаан И.Басалцав

2.